

БАТЛАВ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ГЕОЛОГИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

ГЕОЛОГИЧДЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ



### Нэг: Ажил мэргэжлийн уралдааны зорилго

Геологийн салбарын хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, геологийн судалгааны ажилд ашиглаж буй шинэлэг арга, аргачлал, техник технологи, ажлын туршлага зэргийг харилцан солилцох, түгээх, салбарын тэргүүний ажилтан, аж ахуйн нэгжийг шалгаруулах, олон нийтэд үйл ажиллагааг сурталчилан таниулахад ажил мэргэжлийн уралдааны зорилго оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

#### 2.1. Уралдааны төрөл, бүрэлдэхүүн

1. Геологийн зураглалын ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн 3 хүнтэй/
2. Ерөнхий эрлийн ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн 3 хүнтэй/
3. Геофизикийн ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн нээлттэй/

#### 2.2. Уралдааны шалгуур үзүүлэлт

1. Геологийн зураглалын ажлын төрөлд заасан маршрутын дагуу хээрийн тэмдэглэл хөтлөлт, бичиглэлийн бичсэн байдал, дүгнэлт, зургаар баяжуулсан байдал болон бусад.
2. Ерөнхий эрлийн ажлын төрөлд сонгосон эрлийн хэсгийн зураг зохиосон байдал, уулын ажлын баримтжуулалт, сорьцлолт хийсэн байдал, хээрийн тэмдэглэл хөтлөлт болон бусад.
3. Геофизикийн ажлын төрөлд өгөгдсөн геологийн даалгаврын дагуу ажиллах, геофизикийн ажлын хэмжилт, тэдгээрийн баримтжуулалт, зохиосон зураг, үр дүн болон бусад.

#### 2.2. Уралдааны тов

Геологичдын ажил мэргэжлийн уралдаан нь 2017 оны 09 дүгээр сарын 06-аас 09-ний өдрүүдэд Өвөрхангай аймгийн Сант сумын нутагт орших "Алтай нэгдэл" ХК-ийн геологийн судалгааны Сант-50 нэртэй төслийн талбайд болно.

1. Геологийн зураглалын ажлын уралдаан 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09.00 цагт

2. Ерөнхий эрлийн ажлын уралдаан 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09.00 цагт
3. Геофизикийн ажлын уралдаан 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09.00 цагт
4. "Мезозой, Кайнозойн хурдас" сэдэвт сургалт 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 09.00 цагт
5. Бусад уралдаан, тэмцээн 2017 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 09.00 цагт

### 2.3. Уралдаанд оролцох аж ахуйн нэгжийн мэдүүлгийг хүлээн авах

Уралдаанд оролцох аж ахуйн нэгжийн албан ёсны хүсэлтийг 2017 оны 08 дугаар сарын 26-ны өдөр хүртэл хүлээн авах ба уралдаанд оролцох төрөл, багийн мэдүүлгийг хавсарган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газарт буюу зохион байгуулах Ажлын хэсэгт ирүүлнэ.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 310 тоот өрөө, ГБГ-ын мэргэжилтэн Х.Санчигдорж, Ч.Бямбажав /утас-51264883//

### 2.4. Уралдааны нээлт, хаалтын үйл ажиллагаа

- "Геологичдын ажил мэргэжлийн уралдаан"-ы нээлтийн үйл ажиллагаа 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 09.00 цагт Сант-50 төслийн талбайд эхэлнэ.
- 2017 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр уралдаанд шалгарсан баг, аж ахуйн нэгж, геологичид шагналыг гардуулах хаалтын ажиллагаа болно.

### Гурав. Тавигдах шаардлага

- 3.1. Уралдаанд оролцох аж ахуйн нэгж, баг нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, суурьшлын бүсийн дотоод дэг журмыг мөрдөх;
- 3.2. Аж ахуйн нэгжүүд уралдааны нээлт, хаалтын жагсаалд барих болон талбайд байрлуулах туг, далбаатай байх;
- 3.3. Уралдаанд оролцох хувийн бэлтгэл хангах /гэр, майхан, хоол хүнс, ус, геологийн алх, луп, компас, GPS болон бусад/
- 3.4. Уралдааны үеэр гарах аливаа асуудлыг тухай бүр багийн ахлагч нар зохион байгуулагч болон уралдааны ерөнхий шүүгчтэй хамтран шийдвэрлэх.

### Дөрөв. Шагнал, урамшуулал

Нэг баг 100000 төгрөгийн хураамжийг шагналын санд төвлөрүүлэх ба төрөл тус бүрт оролцох багийн тооноос үл хамааран шагналын сан дах хуримтлалыг шагналт байруудад шат дараалалтайгаар ижил хуваарилна.

Жич: Хураамжийг Монголын геологийн холбооны Хаан банкны 5077310111 тоот дансанд 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс өмнө байршуулах ба гүйлгээний утга хэсэгт аж ахуйн нэгжийн нэр болон "уралдаан" гэж заавал бичнэ.

Үндсэн 3 ажлын төрлүүд тус бүрийг багаар эхний 3 байрт шалгаруулж, дүнг нэгтгэн аж ахуйн нэгжүүдийг шүүгчдийн баг үнэлж, шалгаруулна. Байр эзэлсэн баг, аж ахуйн нэгжийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана. Онцлог болон сонирхолтой дээж авсан багийн тухайн гишүүнийг болон спортын төрөлд түрүүлсэн баг, хувь хүнийг тусгай шагналаар шагнана.

--o0o--